

ОЮУТАН- БАГШ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ АРГЫГ ХЭРЭГЛЭЖ БУЙ БАЙДЛЫГ СУДЛАХ НЬ

Б.Гэсэрмаа Б.Ариунзаяа

МУБИС-ийн Архангайн Багшийн сургууль
gesermaa@msue.edu.mn, ariunzaya.b@msue.edu.mn

Хураангуй

Бүтээлч сэтгэлгээ болон өөгийн нийгмийн зайлшгүй эзэмшвэл зохих хамгийн гол чадвар бөгөөд нийгэм хөгжихийн хэрээр бие даан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, нөхцөл байдалд шүүмжлэлтэйгээр дүн шинжилгээ хийлгэх альтернатив саналыг тунгаан бодох, ухаалаг оновчтой шийдвэр гаргах чадвартай байх нь улам чухал болж байна.

Иймээс суралцагчид шинэ мэдээллийн суурь мэдлэгт тулгуурлан хүлээн авч түүнд дүгнэлт хийж улмаар өөрсдийн үзэл бодлыг өөрчлөхөд хүрдэг тул жинхэнэ сурагч болно. Ийм учраас бүтээлчээр сэтгэх, бодох, орчин бүрдүүлэх нь нэн чухал асуудлын нэг бөгөөд энэхүү орчныг бүрдүүлэхийн тул оюутан-багшийг сургаж хүмүүжүүлэх өдөр тутмын сургалтын үйл ажиллагаанд бүтээлч сэтгэлгээний аргуудыг өргөн хэрэглэж улмаар тухайн сурсан зүйлээ дадлагын хугацаанд туршин хэрэглүүлэх нь чухал асуудал юм.

Түлхүүр үг: Сургалтын арга, бүтээлч сэтгэлгээ, хэрэгцээ, сонирхол, сурах арга

Зорилго: Багшийн сургуулийн Оюутнууд багшлах дадлагын үед бүтээлч сэтгэлгээний аргуудыг хэрхэн хэрэглэж байгааг судлах

Зорилт

1. Бүтээлч сэтгэлгээний аргыг хэрэглэснээр оюутан-багш ба сурагчдад гарсан ахиц өөрчлөлтийг судлах

2. Архангайн Багшийн сургуулийн 3,4-р курсийн оюутнуудын дадлага хийх хугацаанд хийсэн бүтээлч аргын талаархи ажиглалтын судалгаа

3. Бүтээлч сэтгэлгээний аргуудын талаархи асуулгын судалгаа авч, үр дүнг тооцох

Судалгааны арга: Энэхүү ажлыг гүйцэтгэх явцад Баримт бичгийн дүн шинжилгээ, ЕСБ-ийн багш нараас фокус бүлгийн ярилцлага Оюутнуудаас урьдчилан боловсруулсан асуумжийн дагуу мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх аргуудыг ашиглав.

Үндсэн хэсэг:

Бүтээлч сэтгэлгээ гэдэг нь сэтгэлгээний ерөнхий чанар, бөгөөд нэлээд далд гүнд байдаг. Өөрөөр хэлбэл сэтгэхүйн үндсэн чанарууд болох хурд, уян хатан чанар, гүнзгий чанар, агуулга буюу далайц зэрэг чанаруудыг төлөвшүүлснээр бүрэлдэн бий болно. Бүтээлчээр сэтгэнэ гэдэг нь өргөн утгаараа өгөгдсөн санааг ойлгож, далд утгад

дүгнэлт өгч эргэлзээтэй асуудлыг илрүүлэн тавих, түүнийг өөр үзэл санаатай харьцуулан холбогдох бодит баримтаар баяжуулан баттай болгох зэргийг багтаах бөгөөд энэ бүхэнд тулгуурлан өөрийн бодол санааг чөлөөтэй илэрхийлэх чадвар юм. Хүүхэд нэг бүрийн хөгжлийг хангасан сургалтыг зохион байгуулах чадвартай багш болгох хөгжүүлэхэд бүтээлч сэтгэлгээний арга нэн ач холбогдолтой арга болно.

Боловсролын шинэчлэлийг гүйцэтгэх арга замыг эрэлхийлснээс бүтээлч сэтгэлгээний аргыг сургалтад үр бүтээлтэй ашиглах шаардлагыг багшаас шаардаж байгаа учир ирээдүйн багш нарыг энэ чадварт төлөвшүүлэх нь чухал байна. Багшийн чаддаг арга оюутанд чадвар болон төлөвшүүлэх нь багш бэлтгэж байгаа сургуулийн хувьд онцлогтой юм. Оюутан-багш бүтээлч сэтгэлгээний аргуудыг эзэмшиж дадлагын хугацаанд оновчтой хэрэглэх нь чухал асуудлын нэг болж байна.

Бүтээлч сэтгэлгээний арга нь эргэцүүлэн бодох чадвартай, өөрийн үйл ажиллагаанд эзэн болох, үндэслэлүүдийн учир холбогдлыг ойлгох, анхаарлаа төвлөрүүлж, өөртөө итгэлтэй мэтгэлцэн, гаргасан шийдвэрээ ухамсарладаг болгоход чиглэгдсэн сурган хүмүүжүүлэх шинэ арга нь бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх арга болно. Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх аргууд нь өөрийн зорилго бүтэц зэргээрээ шавь төвтэй сургалтын бусад аргуудаас ялгарах бие даасан шинжүүдтэй зэрэгцээ өөртөө нийцсэн хичээлийн бие даасан хэлбэртэй бөгөөд уг хэлбэрийг бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх хичээл гэж нэрлэдэг. (Баасандорж., 2008, х 45)

Үе шат	Сэргээн санах үе	Утга санааг ойлгох үе	Бататгах үе
I	Сэдэв танилцуулах	Текст буюу эх материал	Бататгах
II	Урьдчилан төсөөлөх	Даалгавар гүйцэтгүүлэх	Задлан шинжлэх
III	Жагсаалт гарах	Хэлэлцүүлэг	Чөлөөт бичлэг хийх

Бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх сургалтын арга нь сэргээн санах, утга санааг ойлгох, бататгах гэсэн үетэй бөгөөд үе тус бүр нь тодорхой шат буюу алхмуудтай байна. (Оюунцэцэг, ба бусад, 2002)

Сургалтад бүтээлч сэтгэлгээний аргыг тууштай хэрэглэснээр суралцагчдад бүтээлч сэтгэлгээ

төлөвшүүлж түүний үр дүнд насан туршид нь шаардлагатай энгийн чадваруудыг эзэмшүүлнэ. Оюутан-багш “Багш бэлтгэх сургуульд” суралцах хугацаанд бүтээлч сэтгэлгээний аргуудын заах аргын хичээлүүдэд оновчтой хэрэглэж сурснаар дадлага чанартай, үр өгөөжтэй болдог. Иймээс дадлагын хугацаанд бүтээлч сэтгэлгээний аргыг оюутнууд хэрхэн хэрэглэж байгааг судлалаа.

Судалгааны үр дүн I. Оюутнууд багшлах дадлагын үед бүтээлч сэтгэлгээний аргуудыг хэрэглэснээр ахиц, өөрчлөлтийг судлах

Архангай аймгийн Хүмүүн-II,III, IV сургуулийн дадлага удирдсан багш нартай хийсэн ярилцлагыг дүгнэж үзэхэд бүтээлч сэтгэлгээний аргыг хэрэглэснээр оюутан-багш ба сурагчдад дараах өөрчлөлт гарсан

Оюутан-багш нарт гарсан ахиц өөрчлөлтүүд:	Сурагчдын гарсан ахиц өөрчлөлтүүд
- Олон төрлийн мэдээллээс өөртөө хэрэгтэйг нь сонгох чадварт сургах - Дээд түвшний асуултыг байнга бэлтгэн асууж суралцагчдаар тийм асуулт гаргуулан өргөн ярилцлага зохиож тэдний сэтгэхүйг хөгжүүлэх - Сурагчдыг ямагт урамшуулан дэмжиж байх - Хүүхэд бүрийн хөгжлийн ахицыг тодорхойлох - Ангид бүтээлч сэтгэлгээний олон аргыг сонгон хэрэглэж тэдний хэрэгцээг байнга мэдэрч байхыг эрмэлздэг боллоо.	- Багаар ажиллах чадвартай болж мэдэхийн төлөө мэрийх болсон - Сурагчид багшаасаа айж эмээхгүй, дотно харилцаж, чөлөөтэй санал бодлоо илэрхийлэх болсон - Хичээлд хандах хандлага өөрчлөгдсөн - Суралцах идэвх сонирхол нь дээшилсэн - Олж авсан мэдлэгтээ дүн шинжилгээ хийж мэдлэгээ хамтран бүтээхэд суралцаж эхэлсэн - Өөрийн бодлоо өөрийн үгээр илэрхийлэх чадвар нь сайжирсан - Өөрийн болон сул талыг ажиглан мэдэрч бусдад эергээр нөлөөлөх, хичээлээ давтах сурах хүсэл эрмэлзэл нэмэгдсэн

Судалгааны үр дүн II

МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн 3, 4-р курсийн оюутнуудын дадлага хийх хугацаанд хийсэн ажиглалтын судалгаа

Дадлага хийх хугацаанд оюутнуудын хичээлд сууж анализ хийж байхад оюутан аргаа бүрэн судалж эзэмшээгүй, өөрийн болгох тал дээр дутагдалтай, Оюутнууд яг тухайн сэдэв, сурагчдын нас, сэтгэцийн онцлог анги хамт олны онцлогт тохирсон аргыг сонгон хэрэглэх байдал тохирсон биш, Сонгосон аргаа бүрэн бүтэн хэрэглэж буй оюутан ховор ихэнхдээ нэг аргын нэг элементийг хэрэглэсэн атлаа, өөрөө тухайн аргыг бүрэн бүтэн хэрэглэсэн гэж бодож тайлбарлах, Оюутнууд сурагчдаа баг бүлэг хуваах, ширээ сандлыг нь зөөх засах, багуудад оноо өгөх зэрэг хоёрдогч асуудалд анхаарлаа хандуулж хичээлийн үндсэн зорилгыг хангах, сурагчдаа үнэлэх, оновчтой даалгавар, асуулт өгөх зэрэг гол зүйлийг орхигдуулж байгаа нь ажиглалтын үед алдаа болж харагдлаа.

Ямар нэгэн аргыг зөвхөн өнгөн талаас нь хуулбарлан хэрэглэх явдал газар авч, бүтээлч сэтгэлгээний үндсэн үзэл санаа алдагдаж, улмаар сургалт зорилгодоо хүрч чадахгүй болох хандлага ажиглагдаж байна.

Судалгааны үр дүн III

МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн 3, 4-р курсийн 100 оюутнуудаас асуулгын аргаар судалгааг явуулахад дараахь үр дүн гарсан.

Хүснэгт 1.


№	Дадлагын үед та ямар аргаар голчлон хичээлээ зохион байгуулсан вэ?	Арга	Хувь
1	Ярианы арга	Тайлбарлан таниулах	87%
		Харилцан ярилцах	85%
		Нэгтгэн дүгнэн ярилцах	56%
		Эх сурвалжтай ажиллах	24%
2	Бичвэртэй ажиллах арга	Сурах бичгийн бичвэртэй ажиллах	84%
		Багшийн бэлтгэсэн бичвэртэй ажиллах	11%
3	Үзүүлэн тайлбарлах арга	Зурагт үзүүлэнтэй ажиллах	67%
		Биет үзүүлэн ашиглах	42%
		Видео бичлэг үзүүлэх	13%
4	Бүтээлч сэтгэлгээний арга	Шооны арга, 5 мөрт товхимол бичих арга, инсертийн арга, булангийн арга гэх мэт	45%

Дээрх асуулгаас харахад, тайлбарлан таниулах 87%, харилцан ярилцах арга 85% өндөр байхад Багшийн бэлтгэсэн бичвэртэй ажиллах 11%, Видео бичлэг үзүүлэх 13% буюу хамгийн бага үзүүлэлтэй байна.

Хүснэгт 2

№	БСА нь сургалтын чанарыг дээшлүүлэх үр ашигтай арга мөн үү?	Хувь
1	Үр дүнтэй	86%
2	Үр дүнгүй	7%
3	Сайн мэдэхгүй байна	7%

Эндээс үзэхэд оюутнуудын 86% нь бүтээлч сэтгэлгээний аргыг сургалтын үр ашигтай арга гэдэгтэй санал нийлж байгаа юм.



Зураг 1.

Дээрх хүснэгтээс харахад бүтээлч сэтгэлгээний аргуудаас KWL, Insert-ын арга, Оюуны зураглал хийх аргуудын дундаж үзүүлэлт харьцангуй өндөр байна.

Хүснэгт 4

№	Бүтээлч сэтгэлгээний аргыг хэрэглэхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?	Хувь
1	Хэрэглэх мэдлэг туршлага байхгүй	92%
2	Цаг хугацаа их шаарддаг	75%
3	Тэр бүр тохиромжтой бус	85%
4	Хүүхдүүд ийм аргаар заалгаж дасаагүй байдаг	65%
5	Анги зохион байгуулахад хүндрэлтэй, хэт олон сурагчидтай	55%

Бүтээлч сэтгэлгээний аргыг хэрэглэхэд оюутан-багш нарт багагүй бэрхшээл тулгарч байгаа нь харагдаж байна. Тэдгээрээс хэрэглэх мэдлэг туршлага бага, хичээлдээ тухайн аргаа зөв сонгож хэрэглэж чадахгүй нь харагдаж байна.

Хүснэгт 5.

№	Бүтээлч сэтгэлгээний аргыг хэрэглэсэнээр танд багшлах арга зүйд ямар өөрчлөлтүүд гарсан вэ?	Хувь
1	Сурагчид бүртэй тохируулан харилцах	85%
2	Хичээлийг сонирхолтой аргаар зааж ойлгуулах	90%
3	Ээлжит хичээлийн сайн баялаг төлөвлөх	92%
4	Анги зохион байгуулж сурагчидтай хамтран ажиллах чадвар	86%
5	Сурагчдыг идэвхтэй хичээлд татан оролцуулах	88%
6	Асуулт даалгаврыг оновчтой хэрэглэх	76%



Зураг 2.

Оюутнуудын хувьд бүтээлч сэтгэлгээний аргыг хэрэглэхэд багшлах ур чадвар нэмэгдсэн гэж үзсэн бөгөөд багшлах арга зүйд хичээлийг сурагчдад сонирхолтой зааж, ээлжит хичээлийн сайн төлөвлөх, сурагчдыг идэвхжүүлэх сурагчидтай харилцах чадварт өөрчлөлт орсон.

Дүгнэлт

1. Танхимын сургалтад бүтээлч сэтгэлгээний аргыг тогтмол хэрэглэсэнээр багшийн багшлах ур чадварт ээлжит хичээлийг чанартай төлөвлөх, сурагчдыг идэвхжүүлэх, анги зохион байгуулах, хүүхэд нэг бүрийн танин мэдэх, хүүхдээр мэдлэг бүтээлгэх зэрэг чадвар нэмэгдэх боломжтой
2. Оюутнуудад бүтээлч сэтгэлгээний аргыг хэрэглэхэд тухайн аргыг хэрэглэх мэдлэг дутмаг байгаа учраас хичээлийн сэдэв, анги хамт олны онцлог, хүүхдийн нас сэтгэцийн онцлогт тохируулж сонгон хэрэглэх байдал нь харьцангуй дутагдалтай байна.
3. Оюутан-багш арга зүйг, хэлбэр талаас нь үзээд агуулгыг орхигдуулах тал ч харагдаж байна.

4. Сурган хүмүүжүүлэх зүй, сэтгэл судлалын хичээл, зааж аргын бүх хичээлүүдийн уялдаа холбоог сайжруулж, аргачлал тус бүрийн хичээлд оновчтой хэрэглэсэнээр оюутан-багшийн ур чадвар нэмэгдэх боломж байна.

THE STUDY OF STUDENT-TEACHER'S USAGE OF CRITICAL THINKING METHODS

Abstract

Nowadays, the changing of the education is covering all of educational part. Main observer of that change is a teacher. The main part to require every child's process is to improve and promote their creative thoughts, concentrate professional activities.

Using creative thinking methods regularly in the classroom, teachers will be able to design guiltily classes. Teachers will also be able to encourage children to be active. These will significantly increase students' knowledge and ability.

Зохиогчдын тухай

Баасангийн Гэсэрмаа МУБИС-ийн Архангай багшийн сургуульд сэтгэл судлал, боловсрол судлалын багш, Сурган-Сэтгэл судлалын магистр, сэтгэл судлал, нийгмийн ажилтан мэргэжлээр тус тус сургууль төгссөн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулах асуудлаар судалгааныхаа ажлын чиглэл болгон ажилладаг.

Бямбасүрэнгийн Ариунзаяа МУБИС-ийн Архангай Багшийн сургуульд сэтгэл судлалын багш, сэтгэл судлаач, сэтгэл судлалын магистр. Бага насны хүүхдийн сэтгэл судлалаар судалгааныхаа ажлын чиглэл болгон ажилладаг.

Ном зүй:

1. Баасандорж. Ц., (2008). Сургалтын арга. Улаанбаатар
2. Батхуяг, С., Ичинхорлоо,Ш. (2000). Сурган хүмүүжүүлэх зүйн үндэс. Улаанбаатар
3. Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зүй, Уб., 2002.
4. Идэхтэй сургалтын зуун арга, Уб., 2000.
5. Ичинхорлоо. Ш., (2008). Сургалт. Улаанбаатар
6. Монгол улсын боловсролын их сургууль.,(2013) Лавай эрдэм шинжилгээний бичиг №8., Улаанбаатар